



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1/13.

Амардалай

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

1. Сумын 100 жилийн ой 2023 онд тохиох болсонтой холбогдуулан "Дэлгэрцогт түүхт 100 жил" ном бүтээх, хөрөнгө оруулагчдын судалгаа гаргах, уулзалтын бэлтгэл хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Нарантунгалаг (ЗДТГ-ын дарга)

Гишүүд: О.Улаанхүү ( Улсын бүртгэгч)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам ( 2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий ( 1-р багийн Засаг дарга)

Б.Сармандах (Нийгмийн бодлогын мэргэжилтэн )

Бү.Баярмаа ( Архив, бичиг хэргийн ажилтан)

Б.Эрдэнэцэцэг (ЕБСургуулийн номын санч)

С.Оюунтуяа (Соёлын төвийн номын санч)

2. Номонд оруулах ард иргэдийн материалыг нэгдсэн фонд, файл үүсгэж фото зураг болон бусад материалыг чанарын шаардлага хангахуйц хэмжээнд бүрдүүлж, эх бэлтгэлийн газарт тухай бүр хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Нарантунгалаг)-д үүрэг болгосугай.

3. Сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын уулзалт зохион байгуулахад уугуул, суугуул иргэдийн нэрсийн жагсаалтыг гаргах, уулзалт зохион байгуулахад шаардагдах унаа, шатахуун бусад зардлыг тооцож гаргахыг ажлын хэсгийн ахлагч (С.Нарантунгалаг)-д даалгасугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ